


Төрийн байгуулалтын байнгын хорооны 2014.1. 07-ны  
өдрийн хуралдаанаар батлав.



УХААЛАГ ТӨР РҮҮ ШИЛЖИХ МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН САНДАЧЛАГЫГ ДЭМЖИХ ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХӨРООНООС  
2014 ОНД ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хийх ажлын агуулга, хэлэлцүүлэх хууль, тогтоолын төсөл   | Хариуцах албан тушаалтан                                | Зохион байгуулах хэсэг  | Хугацаа |
|---|--|---|---|---------|
|   | Ухаалаг төр рүү шилжих Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгыг дэмжиж, судалгаанд сууринсан, үйлчилгээнд чиглэсэн, хууль дээдэлсэн ухаалаг төрийн зарчмыг хэрэгжүүлэх чиглэлээр дараах ажлыг зохион байгуулна.   |   |   |         |
| 1 | Ухаалаг төр рүү шилжих ажлын хүрээнд боловсруулан өргөн мэдүүлэгдэх хуулийн төслүүд болон бусад зохион байгуулагдах ажлын талаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүйн яамны удирдлагуудтай ажил хэргийн уулзалт зохион байгуулах, үйл ажиллагаагаа уялдуулах; | A.Бакей   | М.Батчимэг<br>М.Энхболд<br>Н.Батцэрэг<br>С.Дэмбэрэл               | I сард  |
| 2 | Ухаалаг төр рүү шилжих ажлын явц, хэрэгжилтийн байдалд байнгын хяналт тавих, холбогдох байгууллагын удирдлагын мэдээллийг сонсох, мониторинг хийх;   | A.Бакей<br>С.Дэмбэрэл                                   | Н.Батцэрэг<br>С.Баярцогт<br>Ж.Батзандан<br>Су.Батболд<br>Р.Бурмаа | жилдээ  |
| 3 | Дараах хуулийн төслүүдийг боловсруулах, хэлэлцүүлж батлуулах үйл явцад хяналт тавьж ажиллах:<br>А/Засгийн газар, төрийн байгууллагын бүтцийн тухай хуулийн төсөл;  | Д.Эрдэнэбат<br>М.Энхболд<br>Н.Батцэрэг<br>Ч.Сайханбилэг | А.Бакей<br>С.Баярцогт Су.Батболд<br>Б.Гарамгайбаатар<br>Р.Бурмаа  | жилдээ  |

|   |  |   |   |            |
|---|--|---|---|------------|
|   | <p>Б/Төрийн сонгогдсон болон зарим томилогдсон албан тушаалтанд хариуцлага тооцох тухай хуулийн төсөл; В/Монгол Улсын хөгжлийн зорилт хэрэгжилт, хяналтын тухай хуулийн төсөл;</p> <p>Г/Шийдвэр, түүний бүртгэл, хяналтын тухай хуулийн төсөл;</p> <p>Д/Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;</p> <p>Д/Мэргэжлийн хяналтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;</p> <p>Е/Төрийн бус байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;</p> <p>Ё/Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн төсөл;</p> <p>Ж/Ухаалаг төрийн тухай хуулийн төсөл;</p> <p>З/Хотын тухай хуулийн төсөл;</p> <p>И/Нийтийн зар мэдээний тухай хуулийн төсөл;</p> <p>Й/Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл;</p> <p>К/Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төсөл;</p> <p>Л/ Шагналын тухай хуулийн төсөл;</p> <p>М/Төрийн зарим үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх тухай хуулийн төсөл;</p> | <p>Ж.Батзандан<br/>С.Дэмбэрэл<br/>М.Батчимэг<br/>Сү.Батболд</p> | <p>Р.Гончигдорж<br/>Г.Уянга<br/>Б.Наранхүү Х.Тэмүүжин</p> |            |
| 4 | Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлыг судлах ажлын хэсгийн дүгнэлтийг сонсох;  | Л.Цог<br>А.Бакей  | Ажлын хэсгийн болон Байнгын хорооны гишүүд                | II улиралд |
| 5 | Сонгуулийн тухай нэгдсэн хуулийн төслийг бэлтгэх ажлын хэсгийн ажлын тайланг сонсож, хуулийн төслийг өргөн мэдүүлэх;   | Р.Бурмаа<br>А.Бакей   | Ажлын хэсгийн болон Байнгын хорооны гишүүд                | II улиралд |
| 6 | Улс төрийн намын тухай болон Улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулийн төслийг боловсруулах   | С.Баярцогт<br>А.Бакей   | Ажлын хэсгийн болон Байнгын хорооны                       | II улиралд |

|                                  |  |  |  |            |
|----------------------------------|--|--|--|------------|
|                                  | ажлын хэсгийн тайланг сонсож, хуулийн төслийг өргөн мэдүүлэх;  |  | гишүүд   |            |
| 7                                | Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Нийтийн албаны тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх;   | М.Батчимэг<br>Ж.Батзандан<br>С.Батболд<br>Су.Батболд | Ажлын хэсгийн гишүүд                             | II улиралд |
| 8                                | Төрийн байгууллагууд өөрт ногдуулсан чиг үүргийг хэрэгжүүлэхдээ үйл ажиллагаагаа хэрхэн уялдуулж байгааг судлан дүгнэлт гаргаж, саналын төсөл боловсруулах үүрэг бүхий Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 06 тоот тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн дүгнэлтийг хэлэлцэх; | С.Дэмбэрэл   | Ажлын хэсгийн гишүүд,<br>Төрийн албаны зөвлөл    | I сард     |
| 9                                | Улсын Их Хурлын тухай болон Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг нэгтгэн хэлэлцүүлэгт бэлтгэх;  | Р. Гончигдорж  | Ажлын хэсгийн гишүүд                             | I улиралд  |
| 10                               | “Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийн явцыг хэлэлцэх;   | А.Бакей  | Ажлын хэсгийн болон<br>Байнгын хорооны<br>гишүүд | II улиралд |
| 11                               | Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүдтэй ажил хэргийн уулзалтыг зохион байгуулах   | Р.Гончигдорж   | А.Бакей, Н.Батцэрэг<br>Х.Тэмүүжин, Су.Батболд    | I улиралд  |
| <b>Хийгдэх судалгааны ажлууд</b> |  |  |  |            |
| 1                                | Сайн засаглал (good governance) ба ухаалаг засаглал (smart governance)-ийн зарчим, дэлхий нийтийн хандлага, бусад орнуудын туршлагыг судлах;   | Судалгаа<br>шинжилгээний<br>хэлтэс                   | Ч.Сайханбилэг<br>Ажлын хэсгийн гишүүд            | жилдээ     |

|  |   |                                     |   |                  |
|--|---|-------------------------------------|---|------------------|
| 2  | Засгийн газрын чиг үүрэг, бүтцийг боловсронгуй болгох чиглэлээр бодлогын судалгаа, шинжилгээ хийлгэж, зөвлөмж боловсруулах;                     | Судалгааны байгууллага, судлаачдаар | М.Батчимэг<br>С.Баярцогт                          | Эхний хагас жилд |
| 3  | Цахим засаглалын өнөөгийн байдалд нөхцөл байдлын шинжилгээ хийлгэж, зөвлөмж боловсруулах;   | Мэргэжлийн байгууллагатай хамтарна. | Р.Бурмаа, Г.Уянга,<br>Б.Наранхүү<br>Ц.Норовдондог | Эхний хагас жилд |
| <b>Зохион байгуулах нээлттэй сонсгол, хэлэлцүүлэг, семинар</b> |   |                                     |   |                  |
| 1  | Ухаалаг төр рүү шилжих Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгыг хэрэгжүүлэх асуудлаар зарим байгууллага, аймгуудад хэлэлцүүлэг зохион байгуулах; | С.Дэмбэрэл<br>Ажлын хэсэг           | Төрийн албаны зөвлөлтэй хамтарна.                 | II улиралд       |
| 2  | Сонгуулийн нэгдсэн хуулийн төслөөр хэлэлцүүлэг зохион байгуулах;  | Р.Бурмаа                            | Ажлын хэсгийн гишүүд                              | II улиралд       |
| 3  | Улс төрийн намын тухай болон Улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулийн төслөөр хэлэлцүүлэг зохион байгуулах;                                 | С.Баярцогт                          | Ажлын хэсгийн гишүүд                              | II улиралд       |
| 4  | Улсын Их Хурлын Байнгын хорооны нээлттэй сонсголыг зохион байгуулах асуудлаар холбогдох хуульд өөрчлөлт оруулах;                                | Р.Бурмаа                            | Н.Батцэрэг<br>Б.Наранхүү<br>Су.Батболд            | II улиралд       |
| 4  | “Төрийн албаны шинэтгэл” сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулах;  | А.Бакей<br>М.Батчимэг               | Ажлын хэсгийн гишүүд                              | I улиралд        |
| 5  | “Цахим Монгол” хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар нээлттэй сонсгол зохион байгуулах;   | М.Батчимэг                          | Ажлын хэсгийн гишүүд                              | I улиралд        |
| 6  | “Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай” хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр хийсэн ажлын   | С.Дэмбэрэл                          | Ажлын хэсгийн гишүүд                              | I улиралд        |

|   |   |                                      |                                       |             |
|---|---|--------------------------------------|---------------------------------------|-------------|
|   | талаар яамдын мэдээллийг сонсох;  |                                      |                                       |             |
| 7 | “Нутгийн удирдлагыг чадавхжуулах, чадвартай, хариуцлагатай ажиллах нь” онол практикийн бага хурал зохион байгуулах;   | Нутгийн удирдлагын дэд хорооны дарга | Дэд хорооны гишүүд                    | III улиралд |
| 8 | НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн газартай хамтран хэрэгжүүлж байгаа “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь төслийн хүрээнд бүсчилсэн семинар хийх; | Нутгийн удирдлагын дэд хорооны дарга | Дэд хорооны гишүүд                    | II улиралд  |
| 9 | “Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь” хэлэлцүүлэг зохион байгуулах;   | А.Бакей                              | НҮБ-ын хөтөлбөрийн газартай хамтарна. | II улиралд  |

#### **Хяналт шалгалтын ажлын талаар**

|   |   |                       |  |            |
|---|---|-----------------------|--|------------|
| 1 | Байнгын хорооноос 2013 онд гарсан тогтоол, тэмдэглэлээр өгсөн үүргийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллах; | Байнгын хорооны дарга | гишүүд                                 | жилдээ     |
| 2 | Улсын Их Хурлын Тамгын газрын 2013 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэх;                                | Байнгын хорооны дарга | гишүүд                                 | II улиралд |
| 3 | Төрийн албаны зөвлөлийн 2013 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэх;                                      | Байнгын хорооны дарга | гишүүд                                 | II улиралд |
| 4 | Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилттэй зарим газарт танилцах;   | Ажлын хэсгийн гишүүд  | Төрийн албаны зөвлөлтэй хамтарна.      | II улиралд |
| 5 | “Байгууллагын системчилсэн үнэлгээ хийх аргачлал”-ыг хэрэгжүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудын    | С.Дэмбэрэл            | Төрийн албаны зөвлөл, Аудитын газартай | I улиралд  |

|                     |   |                               |  |            |
|---------------------|---|-------------------------------|--|------------|
|                     | тайланг хэлэлцэх явцад анхаарч, дүгнэлт гаргах;   |                               | хамтарна.                                      |            |
| <b>Бусад ажлууд</b> |   |                               |  |            |
| 1                   | Олон улсын болон төрийн бус байгууллагуудын төлөөлөлтэй ажил хэргийн уулзалт, ярилцлага зохион байгуулж байх;                     | Байнгын хорооны дарга         | гишүүд   | жилдээ     |
| 2                   | Байнгын болон Дэд хороо, Улсын Их Хурлын гишүүдээс хийж байгаа ажлын талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслэлээр тогтмол мэдээлж байх; | Байнгын хорооны дарга, гишүүд | Дэд хорооны дарга, гишүүд                      | жилдээ     |
| 3                   | Төрийн алба, Засгийн газрын бүтцийг боловсронгуй болгох чиглэлээр зарим улс, хотын туршлагатай танилцах;                          | Байнгын хорооны дарга         | Ажлын хэсгийн гишүүд                           | жилдээ     |
| 4                   | Дэд хорооны үйл ажиллагааг сурталчлах цахим хуудастай болох;  | Дэд хорооны дарга нар         | гишүүд   | жилдээ     |
| 5                   | Зарим орны нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаатай танилцах;  | Байнгын хорооны гишүүд        | НҮБ-ын хөтөлбөрийн хөгжлийн газартай хамтарна. | II улиралд |

### ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРОО